

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 5 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Дүрэм, журам батлах тухай

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.3-т заасныг үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. ~~“Үнэт цаасны хорооны ажилтны ёс зүйн хэм хэмжээний дүрэм”~~ /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 74 дүгээр тогтоолоор хүчингүй/, “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах тухай журам”, “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудаас үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайлан авах тухай журам” /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор хүчингүй/ -ыг тус тус хавсралтаар баталсугай.

2. Эдгээр журам батлагдсантай холбогдуулан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах тухай журам” батлах тухай Үнэт цаасны хорооны 1995 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоол, “Мэдээ тайлан авч байх тухай” мөн оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 32 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Шинээр батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт тавих, хувь нийлүүлэгчдийн эрх үүргийг тогтоох талаарх Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх, сангийн дүрэм батлах, нийтэд санал болгон гаргах үнэт цаасны танилцуулга бэлтгэх, хувь нийлүүлэгчдэд мэдээлэл хүргэх, бүртгэл тайлан гаргах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Үнэт цаасаа нийтэд санал болгох замаар мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх, үнэт цаасны арилжаанд оролцож хөрөнгөө арвижуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаас худалдан авах, худалдах зорилгоор Хөрөнгө оруулалтын санг компанийн хэлбэрээр үүсгэн байгуулна.

1.3. Хөрөнгө оруулалтын сан нь/цаашид “сан” гэх/ нээлттэй болон хаалттай гэсэн хэлбэртэй байна.

1.4. Үнэт цаасаа бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг санг нээлттэй сан, үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр үнэт цаас гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй санг хаалттай сан гэнэ.

1.5. Сан нь зохион байгуулалтын төрөл хэлбэрээ Компанийн тухай хуульд заасны дагуу өөрчилж болно.

1.6. Сан нь оноосон нэртэй байх бөгөөд нэрийн ард “ХОС” гэсэн тэмдэглэлтэй байна.

ХОЁР. Сангийн үйл ажиллагаа явуулах зайлшгүй нөхцөл

2.1. Сан нь дараахь шаардлагыг хангасан нөхцөлд үйл ажиллагаагаа явуулна:

2.1.1. Үнэт цаасны хорооноос /цаашид “Хороо” гэх/ үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан байх;

2.1.2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлсэн байх;

2.1.3. Хөрөнгө оруулалтыг удирдах итгэмжлэлийн гэрээ, хадгаламжийн үйлчилгээний тухай гэрээ, хувь нийлүүлэгчдийн бүртгэл хөглөх тухай гэрээ, аудитын тухай гэрээг холбогдох иргэн, хуулийн этгээдтэй тус тус байгуулсан байх.

2.2. Сан нь бүрэн эрхээ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд дараахь этгээдтэй гэрээ байгуулж ажиллана:

2.2.1. Сангийн менежер;

2.2.2. Үнэт цаасыг хадгалагч;

2.2.3. Сангийн бүртгэгч;

2.2.4. Сангийн хянагч.

2.3. Гэрээний үлгэрчилсэн загварыг Хорооноос тогтоож мөрдүүлнэ.

2.4. Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулахаар Хорооноос эрх авсан хүмүүс сангийн менежер, үнэт цаас хадгалагч, бүртгэгчээр ажиллана.

2.5. Сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг, 19 дүгээр зүйлд заасан Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд мөн хуулийн 26 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

ГУРАВ. Санг бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох

3.1. Сангийн үйл ажиллагаа явуулахыг хүссэн этгээд Хороонд өргөдөл гаргана. Өргөдөлд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4-т зааснаас гадна доорхи мэдээллийг тусгасан байна:

3.1.1. Сангийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

3.1.2. Сангийн дүрмийн хуулбар;

3.1.3. Сангийн удирдлагын нэр, хаяг;

3.1.4. Сангийн аудит хийлгэхээр тохирсон этгээдийн нэр хаяг;

3.1.5. Нийтэд санал болгож гаргасан үнэт цаасны тоо, ширхэг;

3.1.6. Сангийн менежертэй байгуулсан гэрээний хуулбар;

3.1.7. Сангийн гэрээ байгуулсан үнэт цаасны хадгаламжийн байгууллагын нэр хаяг;

3.1.8. Сангийн менежер, бусад ажилтанд үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулахаар олгосон эрхийн үнэмлэхийн хуулбар.

3.2. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу өргөдлийг хүлээн авч хянан хууль, журамд нийцсэн гэж үзвэл хүлээн авснаас хойш 1 сарын дотор сангийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгож, санг бүртгэж авна. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзвал энэ тухайгаа өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

3.3. Сан нь менежер, үнэт цаас хадгалагч, бүртгэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

ДӨРӨВ. Сангийн хувь нийлүүлсэн хөрөнгө, дүрэм

4.1. Сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 100,0 сая төгрөгөөс доошгүй байна.

4.2. Сангийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.7-д зааснаас гадна доорхи зүйлийг тусгасан байна:

4.1.1. Сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сангийн хэлбэр, удирдлагын бүтэц, компанийн болон хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх, ногдол ашиг хуваарилах журам;

4.1.2. Сангийн цэвэр ашгаас хийх хөрөнгө оруулалтын зөвшөөрсөн хэмжээ, сангийн хөрөнгөнөөс үнэт цаас худалдаж авах эсхүл үнэт цаас гаргаж болохыг зөвшөөрсөн дүн;

4.1.3. Санг өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах журам;

4.1.4. Сангийн үйл ажиллагааны хандлага, чиглэл, үнэт цаасны багцыг бүрдүүлэх хувь хэмжээ, нээлттэй сангийн үйл ажиллагаанаас олох цэвэр орлогыг тодорхойлох болон хувьцаа эзэмшигч хувьцаагаа буцааж худалдахад түүнд төлбөр хийх журам, үйл ажиллагааны хязгаарлалт зэргийг тусгасан сангийн хөрөнгө оруулалтын бодлого;

4.1.5. Сангийн удирдлага болон менежер өөрөөсөө хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд уг хөрөнгө оруулалтын хэлбэр ба зориулалтын талаарх мэдээлэл;

4.1.6. Сангийн хөрөнгө оруулалтын мэдүүлэг;

4.1.7. Сангийн хувьцааг гаргах, байршуулах журам;

4.1.8. Сангийн менежер, хадгалагч, бүртгэгч, хянагчид олгох урамшуулал.

ТАВ. Сангийн удирдлага

5.1. Сангийн удирдлагыг хувь нийлүүлэгчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

5.2. Сангийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг сангийн менежер хэрэгжүүлнэ.

5.3. Сангийн хувь нийлүүлэгчдийн хурал Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхтэй байна:

5.3.1. Сангийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай шийдвэр гаргах;

5.3.2. Хөрөнгө оруулалтын мэдүүлэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай шийдвэр гаргах;

5.3.3. Үнэт цаасны богц/портфель/ удирдах тухай Сангийн менежертэй байгуулсан гэрээг батламжлах;

5.3.4. Сангийн менежертэй байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаанаас нь өмнө цуцлах;

5.3.5. Үнэт цаас бүртгэгч, хадгалагчтай байгуулах гэрээг батлах;

5.3.6. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг тогтоох;

5.3.7. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн болон менежерийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах.

5.4. Сангийн хувь нийлүүлэгчдийн хурал сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээтэй холбоотой ямарч асуудлыг өөрийн санаачилгаар холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх эрх эдэлнэ.

5.5. Сангийн хувь нийлүүлэгчдийн хуралд хувь нийлүүлэгч биеэр оролцож чадахгүй болсон тохиолдолд Сангийн бусад хувь нийлүүлэгчид эсхүл түүнийг бүрэн төлөөлөх итгэмжлэгдсэн этгээд хуулийн дагуу олгосон итгэмжлэлийн дагуу төлөөлөн оролцож болно. Төлөөлөн оролцогч этгээд тухайн сангийн менежер байж болохгүй.

5.6. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.6.1. Үнэт цаасны богц удирдах тухай сангийн менежертэй гэрээ байгуулах, биелэлтэнд хяналт тавих, дүнг авч хэлэлцэх;

5.6.2. Санд ажилладаг бусад этгээдтэй гэрээ байгуулах, өөрчлөх, дүгнэх, цуцлах;

5.6.3. Сангийн үнэт цаасны богцыг удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүхий л асуудлаар сангийн менежерээс мэдээлэл гаргуулан авах;

5.6.4. Нээлттэй сангийн төлөөлөн удирдах зөвлөл энэхүү журмын 5.6-д зааснаас гадна нээлттэй сангийн хувьцааг худалдан авах үеийн түүний цэвэр хөрөнгийн өртгийн өдөр тутмын үнэлгээг хийх;

5.6.5. Хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан менежерийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай жил бүрийн тайлан, түүнчлэн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалтай холбоотой бусад мэдээллийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх.

5.7. Сангийн менежер нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхгүй оролцоно.

5.8. Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь брокерийн үйл ажиллагаа явуулах, түүнчлэн тухайн сангийн менежер болон түүний удирдлагад ажиллах мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

5.9. Сангийн хяналтын зөвлөл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

5.10. Хяналтын зөвлөлийн гишүүдийг Компанийн тухай хуульд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгоно.

5.11. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, сангийн менежер, үнэт цаас бүртгэгч, үнэт цаас хадгалагч, хянагч нь Хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

5.12. Сангийн менежер/гүйцэтгэх удирдлага/ нь сангийн дүрэм болон сантай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд үнэт цаасны богцыг удирдах мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

5.13. Сангийн менежер нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.13.1. Санд үнэт цаас худалдан авахад зориулж мөнгөн хөрөнгө төвлөрүүлэн хөрөнгө оруулалт хийх тухай шийдвэр гаргах, сангийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэлцэл хийх;

5.13.2. Санд төвлөрүүлсэн хувьцааны богцыг удирдах;

5.13.3. Сантай байгуулсан гэрээнд заасны дагуу санг төлөөлөх;

5.13.4. Сангийн дүрэм, гэрээ, хөрөнгө оруулалтын мэдүүлэгт заасан зүйлийг чанд биелүүлж, үнэнч шударгаар ажиллах.

5.14. Менежер нь үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар сангийн Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.

5.15. Сангийн менежерийн өмчлөлд буй эд хөрөнгө нь сангийн хөрөнгөөс заавал тусгаарлагдсан байна.

5.16. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл үнэт цаас хадгалагчтай гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр сан нь өөрийн үнэт цаасыг үнэт цаас хадгалагчид шилжүүлнэ.

5.17. Шударга бус үйл ажиллагаа явуулсан этгээд, удирдлагатай нэгдмэл сонирхолтой этгээд тухайн сангийн үнэт цаас хадгалагч, бүртгэгчээр ажиллахыг хориглоно.

5.18. Сангийн хувь нийлүүлэгчдийн нэгдсэн бүртгэл хөтлөх үүргийг үнэт цаас бүртгэгч гүйцэтгэнэ.

ЗУРГАА. Сангийн нэгдмэл сонирхолтой этгээд

6.1. Дараах тохиолдлыг сангийн удирдлагатай нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

6.1.1. Компанийн тухай хуулийн 97.1.1-97.1.8-д заасан этгээд;

6.1.2. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, менежер, үнэт цаас хадгалагч, бүртгэгч, хянагч, сангийн бусад ажилтнууд;

6.1.3. Тухайн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн буюу хуулийн этгээдэд хяналт тавьдаг этгээд;

6.1.4. Тухайн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн болон хуулийн этгээдийн хяналт дор ажилладаг этгээд;

6.1.5. Тухайн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн болон хуулийн этгээдтэй хамт гуравдагч этгээдийн хяналт дор ажилладаг этгээд;

6.1.6.Тухайн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн болон хуулийн этгээдийн итгэмжлэгдсэн хүн, тэдгээртэй гэрээгээр ажилладаг этгээд.

6.2.Тухайн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн эсхүл хуулийн этгээд хяналт тавьдаг этгээд гэдэгт аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн эсхүл хуулийн этгээдээс гаргаж буй шийдвэрийг өөр хөндлөнгийн этгээд тодорхойлох, тухайн этгээдээс ийм шийдвэр гаргахад бодитой нөлөөлөх боломжийг ойлгоно.

ДОЛОО. Сангаас хувь нийлүүлэгчдэд хүргэх мэдээлэл

7.1. Сангийн удирдлага нь “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 26.8, энэхүү журмын 7.2-т заасан мэдээллийг хувь нийлүүлэгчдэд хагас жил тутам хүргэж, мэдээллийн нэг хувийг тухай бүр Хороонд ирүүлнэ.

7.2. Хувь нийлүүлэгчдэд хүргэх мэдээлэлд доорх зүйлийг тусгасан байна:

7.2.1. Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг гүйлгээ хийгдсэн өдөр тутам тооцон гаргасан /тооцох аргачлалыг хувь нийлүүлэгчдийн хурлаар тогтоож мөрдөнө/ тухай мэдээлэл;

7.2.2. Сангийн нэгж хувьцааны үнэлгээнд /тооцох аргачлалыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоож хувь нийлүүлэгчдийн хурлаас батална/ орсон өөрчлөлтийн талаархи мэдээлэл;

7.2.3. Сангаас төлбөр тооцооны байгууллагатай байгуулсан гэрээ, Хорооноос зөвшөөрснөөр мэргэжлийн байгууллагуудаас болон өөрийн тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээний талаарх мэдээлэл;

7.2.4. Дүрэмд тусгагдсаны дагуу сангаас гарсан гишүүдтэй хийх төлбөр тооцооны талаарх мэдээлэл;

7.2.5. Компанийн удирдлага, менежерээс болон хувь нийлүүлэгчээс оруулсан хөрөнгийн ашиглалт зарцуулалттай холбогдох мэдээлэл;

7.2.6. Сангийн гаргасан үнэт цаасны 5-аас дээш хувийг эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт.

7.3. Сангаас нийтэд санал болгох үнэт цаасны тухай танилцуулга, мэдээлэл, тайлангийн хураангуй, үнэт цаасны зах зээлийн үнэ, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээллийг олон нийтэд Хорооноос тогтоосон журмын дагуу хүргэнэ.

НАЙМ. Сангаас нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулга

8.1.Сангаас нийтэд санал болгох үнэт цаасны талаархи танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.4-д зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна:

8.1.1.Сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, заасан хөрөнгө оруулалтын бодлого;

8.1.2.Хорооны зөвшөөрснөөр хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан шимтгэл тооцох аргачлал, журам;

8.1.3.Сангийн удирдлага, ажилтнууд, хяналтын багцыг эзэмшигч, гэрээт хөрөнгө оруулалтын менежментийн компанийн талаархи мэдээлэл;

8.1.4.Сангийн менежер, үнэт цаас хадгалагч, бүртгэгчтэй байгуулсан гэрээний үндсэн нөхцөл, талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, явуулах үйл ажиллагаа, гэрээний хүчинтэй байх хугацаа, шагнал урамшуулал олгох нөхцөл, түүний хэмжээ, үйлчилгээний хөлс.

8.2.Сан нь энэхүү журмын 8.1-д заасан зүйлүүдийг тусгасан танилцуулгыг тухай бүр Хороонд ирүүлнэ.

ЕС. Сангийн үйл ажиллагаанд
тавигдах хязгаарлалт

9.1. Санд Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 26.9-д зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.1.1. Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг зориудаар буруу тооцох, энэ талаар нийтэд буруу мэдээлэл өгөх;

9.1.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр арилжигдаж байгаа үнэт цаасны үнэ ханшийг санд бүртгэж тооцохдоо түүнээс зөрүүлж өөр үнээр бүртгэх;

9.1.3. Сангийн удирдлагатай нэгдмэл сонирхолтой этгээдийн болон сантай гэрээ байгуулсан үнэт цаас хадгалагч, бүртгэгчийн эзэмшлийн үнэт цаасыг худалдан авах;

9.1.4. Сангийн үйл ажиллагааны талаар буруу ташаа мэдээлэл тараах;

9.1.5. Нэгдэн нийлэхээс бусад тохиолдолд бусад сангийн хувьцааг өөрийн активт оруулан бүртгэх;

9.1.6. Сангийн хувьцаанаас өөр үнэт цаас гаргах.

АРАВ. Сангийн санхүүгийн
тайлан, хяналт

10.1. Сан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, үнэт цаасны гүйлгээ, орлого, зарлага, ашиг, алдагдлын болон хувьцааны нэгж эрх, сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний бүртгэл хөтөлнө.

10.2. Сан нь тайланг цэвэр хөрөнгийн үнэлгээг/үнэт цаасны арилжаагаар өдөр бүр үнэт цаасны ханш өөрчлөгдөх учир/ гүйлгээ хийгдсэн өдөр тутам тооцож маягт № Б2-4-ийн дагуу гаргана. Тухайн сангийн хөрөнгө оруулагч нь сангийн хөрөнгийн үнэлгээ, үнэт цаасны үнэ ханшийн талаар хүссэн үедээ мэдээлэл авах эрхтэй.

10.3. Сангийн тайланд дараахь зүйлийг нэмж тусгана:

10.3.1. Тайлант хугацааны эцсийн сангийн цэвэр хөрөнгийн тооцоо;

10.3.2. Сангаас гаргасан хувьцааны тоо;

10.3.3. Сангийн удирдлага болон менежерээс санд оруулсан хөрөнгийн тайлан;

10.3.4. Орлого, зарлага, үр ашиг, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ.

10.4. Сангаас хөрөнгө оруулагчдад хүргэх танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргана. Танилцуулгад дараах зүйлийг заавал тусгасан байна:

10.4.1. Сангийн анхны болон өмнөх танилцуулгад гарсан өөрчлөлт, нэмэлтүүд;

10.4.2. Санхүүгийн тайлан тэнцлийн хураангуй;

10.4.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн болон хяналтын зөвлөлийн тайлан;

10.4.4. Сангийн менежер болон Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалт;

10.4.5. Сангийн гаргасан үнэт цаасны 5-аас дээш хувийг эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

10.4.6. Бусад шаардлагатай мэдээлэл.

10.5. Сан нь хөрөнгө оруулагчдад хүргэх танилцуулгын нэг хувийг тухай бүр Хороонд ирүүлнэ.

10.6. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Хороо, сангийн хянан шалгах зөвлөл/хянагч/, менежер, хөрөнгө оруулагч хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГ. Санг татан буулгах,
хариуцлага

11.1. Санг иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан журмын дагуу өөрчлөн байгуулж, татан буулгана.

11.2. Энэхүү журмын заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН
 (цэвэр хөрөнгийн)ТАЙЛАН №..

200.. оны ..-р сарын ..-ны өдөр

Сангийн нэр _____ (нээлттэй, хаалттай) доогуур нь зурах

Сангийн гишүүдийн тоо: _____

Сангийн эхний үлдэгдэл: _____ нэгж хувьцааны үнэ: _____

хувьцааны тоо:

| № | Үнэт цаасны нэр | Эхний үлдэгдэл /тоо ширхэг/ | Худалдаж авсан | | | Худалдсан | | | Эхний үлдэгдэл | | |
|---|-----------------|-----------------------------|----------------|----------|-----------|------------|----------|-----------|----------------|----------|-----------|
| | | | Тоо ширхэг | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо ширхэг | Нэгж үнэ | Үнийн дүн | Тоо ширхэг | Нэгж үнэ | Үнийн дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | | | | | | | | | | | |
| | ДҮН | | | | | | | | | | |

-Харилцахын үлдэгдэл: _____

-ТТХА дахь үлдэгдэл: _____

-Кассын үлдэгдэл: _____

-Сангийн эзэмшиж буй үнэт цаасны ногдол ашиг: _____

-Шинээр орсон _____ -Гарсан гишүүдийн
 гишүүдийн хөрөнгө: _____ хөрөнгө: _____

-Нэмэгдсэн хувьцааны тоо: _____ -Гарсан хувьцааны тоо: _____

-Орсон гишүүдийн тоо: _____ -Гарсан гишүүдийн тоо: _____

-Үйлчилгээний хураамж: _____

Эцсийн үлдэгдэл: _____ Нэгж хувьцааны үнэ: _____
 Хувьцааны тоо: _____

Тайлан гаргасан: _____

Тайланг хянасан: _____

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ҮНЭТ
ЦААСНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХИ МЭДЭЭ,
ТАЙЛАН АВАХ ЖУРАМ

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Мэргэжлийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, тайланг хүлээн авч дүгнэлт хийх, бодлого боловсруулах болон шийдвэр гаргахад ашиглах, хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж зохицуулах, үнэт цаасны зах зээлд оролцогчдыг мэргэжлийн байгууллагатай холбоотой мэдээллээр хангахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 19.2.1-д заасны дагуу холбогдох мэдээ, тайланг энэхүү журмын дагуу тогтоосон хугацаанд Хороонд ирүүлэх үүрэг хүлээнэ.

ХОЁР. Хороонд ирүүлэх мэдээ

2.1. “Хөрөнгийн бирж” ХК-иас дараах мэдээг дотооддоо гаргадаг үзүүлэлтийн дагуу гаргана.

2.1.1. Арилжааны ерөнхий мэдээ

2.1.2. Үнэт цаасны ханшийн мэдээ

2.1.3. Хөрөнгийн биржийн ерөнхий болон салбарын индекс

2.1.4. Үнэт цаасны арилжааны тайлан

2.1.5. Үнэт цаасны арилжааны сар бүрийн тоймыг нэгтгэсэн жилийн мэдээ

2.1.6. Үнэт цаасны арилжааны мэдээ

2.1.7. Дуудлага худалдааны үнийн дүнгийн мэдээ

2.2.8. 2.1.1-2.1.4-д заасан мэдээг сар бүрийн 5-ны дотор, 2.1.5-2.1.7-д заасан мэдээг дараа оны 01 дүгээр сарын 05-ны дотор гаргаж Хороонд ирүүлнэ.

2.2. “Төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХК-иас дараах мэдээ, судалгааг дотооддоо гаргадаг үзүүлэлтийн дагуу гаргана.

2.2.1. Брокер, дилерийн компанийн гүйлгээний мэдээ

2.2.2. Бондын гүйлгээний мэдээ/бондын төрөл бүрээр/

2.2.3. Биржийн бус арилжааны гүйлгээний мэдээ

2.2.4. Төрийн өмчийн хувьцааг Хөрөнгийн бирж болон дуудлагаар худалдсан гүйлгээний мэдээ

2.2.5. Үүргийн гүйцэтгэл хангуулах зорилгоор зээлийн барьцаанд тусгаарласан хувьцааны мэдээ

2.2.6. Ногдол ашиг болон ногдол хувь тараалтын мэдээ

2.2.7. Шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа тусгаарласан судалгаа

2.2.8. Арилжааны болон арилжааны бус гүйлгээний шимтгэлийн судалгаа

2.2.9. Данс нээлгэсэн байдлын судалгаа

2.2.10. 2.2.1-2.1.9-д заасан мэдээ, судалгааг сар бүрийн 5-ны дотор гаргаж Хороонд ирүүлнэ.

ГУРАВ. Хороонд ирүүлэх тайлан

3.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

3.1.1. Тайлан гаргахдаа Монгол улсын Сангийн сайдын 2000.04.13-ны өдрийн 64 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга бэлтгэх үлгэрчилсэн заавар”-ыг баримтална.

3.1.2. Тайланд Үнэт цаасны хорооны 2003.02.21-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам”-ын 3.1, 3.2-т заасан тодруулгыг тусгана.

ДӨРӨВ. Мэдээ, тайланг хянаж,
дүгнэлт гаргах

4.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас журмаар тогтоосон хугацаанд ирүүлсэн мэдээ тайланг Хорооны Зах зээл зохицуулалтын хэлтэс хүлээн авч судлан хянаж байна. Шаардлагатай бол нэгдсэн дүгнэлт гарган дээрх байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн танилцуулгыг шийдвэрийн төслийн хамт боловсруулан Хорооны хуралдаанд хэлэлцүүлж олон нийтэд мэдээлж байх үүрэг хүлээнэ.

ТАВ. Хүлээлгэх хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчиж хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38.1.1-д заасан захиргааны шийтгэл ногдуулна.

--oOo--